

**Сэдэв:** Асуудал, асуудлыг үүсгэгч, асуудлаас гарах гарц

**Илтгэгч:** ИЗОУИС-ийн Эрх зүйн 3-р курсын оюутан Ч.Нямцоож

### **Илтгэлийн агуулга**

**Нэг: Оршил**

- Судалгааны зорилго
- Судлах болсон үндэслэл
- Судлагдсан байдал
- Судалгааны арга

**Хоёр: Үндсэн хэсэг**

**Сэдэв:** Асуудал, асуудлыг үүсгэгч, асуудлаас гарах гарц

- Асуудал буюу Авилгын тухай ойлголт, Монгол Улс дахь авилгын өнөөгийн байдал
- Асуудлыг үүсгэгч буюу авилгыг үүсгэгч хүчин зүйлс
- Асуудлаас гарах гарц буюу иргэдийг эрх зүйн ухамсартай болгох нь

**Гурав: Дүгнэлт**

**Дөрөв: Ашигласан материал**

## Оршил

**Судалгааны зорилго:** Авилгыг үүсгэж буй хүчин зүйлс болоод түүний нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллийг тодорхойлж, нийгмийн хорт хавдар болсон авилгыг эмчлэх арга замыг тодорхойлоход оршино.

**Судлах болсон үндэслэл:** Залуу хүний ихийг хийж бүтээх гэсэн хүсэл түмүүлэл, зоригыг мохоож буй манай нийгмийн гаж үзэгдэл нь авилга, хээл хахууль гэдэг энэ зүйл болоод байна. Ерөөс авилга иргэдийн дунд төрийн байгууллагын нэр хүндийг маш ихээр унагаадаг. Мөн иргэдийн төрийн байгууллага болон төрдөө итгэх итгэлийг бууруулдаг. Авилга нь Монгол Улсын Үндсэн хуулинд “хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно...”<sup>1</sup> гэж заасан заалтыг ямагт зөрчдөг, бидний ардчилсан нийгмийн ололт амжилт болох шинэ үндсэн хуулийн минь үндсэн үзэл санааг үгүйсгэдэг үйлдэл байдаг. Өнөөгийн бидний ардчилсан нийгэмд авилгын учруулж буй хор нөлөө их байна одоо л бид үүнийг таслан зогсоохгүй бол маргааш гүйх хэрэг гараад байгаа юм. Иймд илтгэгч миний бие энэхүү сэдвийг сонгон судлах болсон.

**Судлагдсан байдал:** Энэ сэдвээр эрдэмтэн, судлаачдын бие дааж болон хамтран гаргасан ном зохиол, иргэдэд зориулсан судалгаа шинжилгээний гарын авлагууд нэлээдгүй их байгаа юм. Харин миний хувьд ирээдүйн Монгол Улсын шинэ түүхийг бүтээлцэх нэгэн болохоор тэр дундаа нийгмийг эмчлэгч хуульч гэдэг энэ нэр хүндтэй мэргэжлийг эзэмшихээр сурч байгаа учир авилгыг талаар судлах, түүнийг таслан зогсоох арга замыг нээн илрүүлэх нь миний хувьд үүрэг мөн. Иймд энэ үүргээ ухамсарлан авилгыг устгах хамгийн энгийн бөгөөд шилдэг арга нь иргэдийг эрх зүйн зөв ухамсартай болгох явдал гэдгийг тодруулан гаргаж судалсанаараа миний энэхүү илтгэл бусдаас ялгарна.

**Судалгааны арга:** Энэхүү илтгэлээ бичихдээ эрдэмтэн, судлаачдын авилгын талаархи бүтээл, авилгатай холбоотой хаирлцааг зохицуулж буй хууль тогтоомжийг шинжлэн судлаж, шинжлэх ухааны харьцуулах, логик, анализ, синтез зэрэг аргуудыг ашиглан бичсэн болно.

---

<sup>1</sup> “Монгол Улсын Үндсэн хууль”-ийн 14-р зүйлийн 2 дох хэсэг ..., УБ хот. 1992 он.

## Үндсэн хэсэг

**Сэдэв:** Асуудал, асуудлыг үүсгэгч, асуудлаас гарах гарц

1. Асуудал буюу Авилгын тухай ойлголт, Монгол Улс дахь авилгын өнөөгийн байдал
2. Асуудлыг үүсгэгч буюу авилгыг үүсгэгч хүчин зүйлс
3. Асуудлаас гарах гарц буюу иргэдийг эрх зүйн ухамсартай болгох

**Нэг: Асуудал буюу Авилгын тухай ойлголт, Монгол Улс дахь авилгын өнөөгийн байдал**

### 1.1. *Авилгын тухай ойлголт*

Юуны өмнө авилга гэж чухам юу болохыг товч тодорхойлоё: Авилгал авагч нь өгөгчөөс хууль бус төлбөр /мөнгөн болон бусад/ гаргуулах үйл ажиллагааг авилга хэмээн тодорхойлж болно. Харин Авилгын эсрэг хууриар “Авилга” гэж албан тушаалтан албан тушаалын эрх мэдлээ хувийн ашиг хонжоо олоход урвуулан ашиглах, бусдад давуу байдал олгох, иргэн, хуулийн этгээдээс тэрхүү хууль бус давуу байдлыг олж авах үйлдэл, эс үйлдэхүйгээр илрэх аливаа эрх зүйн зөрчлийг хэлнэ<sup>2</sup> гэж тодорхойлсон байна. Энэ тодорхойлолтоос ашиг хонжоо, албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглах, давуу байдал гэсэн өөр хоорондоо ялгаа бүхий ойлголтууд урган гарч ирж байгаа юм. Тэгвэл эдгээр ойлголтуудыг Авилгын эсрэг хуульд хэрхэн тусгасныг авч үзэе:

- “*ашиг хонжоо*” гэж албан тушаалтан албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглаж бусдад давуу байдал олгосны төлөө өөрт нь болон бусдад буй болох эдийн болон эдийн бус ашигтай байдлыг хэлнэ<sup>3</sup>.
- “*албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглах*” гэж албан тушаалын эрх мэдлийг албаны эрх ашгийн эсрэг буюу хувийн ашиг сонирхолоо гүйцэлдүүлэх зорилгод ашиглаж хийх ёстой үйлдлийг хийхгүй байх, хийх ёсгүй үйлдэл хийхийг хэлнэ<sup>4</sup>.
- “*давуу байдал*” гэж албан тушаалтан албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашигласнаар хувь хүн, хуулийн этгээдэд буй болох эдийн болон

<sup>2</sup> “Авилгын эсрэг хууль”-ийн 3.1.1 ..., УБ хот. 2006 он.

<sup>3</sup> “Авилгын эсрэг хууль”-ийн 3.1.2 ..., УБ хот. 2006 он.

<sup>4</sup> “Авилгын эсрэг хууль”-ийн 3.1.3 ..., УБ хот. 2006 он.

эдийн бус ашигтай байдлыг хэлнэ<sup>5</sup> гэж тус тус хуульчлан тодорхойлсон байна.

## 1.2. Монгол Улс дахь авилгын өнөөгийн байдал

Монголчууд бидний 20 гаруй жил замнасан ардчиллыг үгүйсгэж буй манай нийгмийн хамгийн том асуудал нь авилга гэдэгтэй хэн бүхэн санал нэгдэх биз. Монгол Улс дахь авилгын өнөөгийн байдлыг тодруулах үүднээс авилгын түвшингийн талаар дэлхий дахинд хүлээн зөвшөөрөгдсөн нэгэн судалгааны дүнг харуулая: Энэ бол олон улсын “Трансперенси Интернешнл” байгууллагаас жил бүр дэлхийн улс орнуудын авилгын индексийг тодорхойлдог судалгаа юм. Аргачлалын хувьд авилгын түвшинг 0-10 оноогоор дүгнэж, хамгийн бага авилгатай буюу авилгыг хязгаарлаж чадсан орнууд 10-аас эхэлж, авилгыг дээд зэргээр цэцэглүүлсэн нь тэг оноо уруу уруудах байдлаар тооцож харуулдаг онцлогтой. Бид хаана явна вэ?


<b>Он</b>	<b>Монголын оноо</b>	<b>Монголын эзэлсэн байр</b>	<b>Нийт судалгаанд хамрагдсан улс орон</b>
2004	3.0	85	145
2005	3.0	85	159
2006	2.8	99	180
2007	2.8	102	180
2008	3.0	106	180
2009	3.0	120	180
2010	2.7	116	178

Судалгааны дүнгээс харахад сүүлийн 7 жилийг харахад юу ч өөрчлөгдсөнгүй. Өөрөөр хэлбэл, Монгол Улс авилгыг амжилттай “хөгжүүлж” буй улс орнуудын тэргүүн эгнээнд явж байна. Бид оноо нь буураагүй ч эзлэх байр нь

<sup>5</sup> “Авилгын эсрэг хууль”-ийн 3.1.4 ..., УБ хот. 2006 он.

өөрчлөгдөөгүй гэдэг нь манай улсаас бусад нь авилгатай тэмцэх чиглэлээр ажиллаж чадсан гэсэн үг.<sup>6</sup>

2010 оны Авилгын индексийг харуулсан дэлхийн газрын зураг



**Тайлбар:** Тод улаан нь авилгаараа тэргүүлэгч орнууд

Энэ бүх судалгаа нь Монгол Улсад авилга ямар их байгааг харуулаад зогсохгүй сүүлийн жилүүдэд энэ үзэгдэл огт буурахгүй харин ч тогтвортой байдлаа хадгалан улам бүр цэцэглэн хөгжөөд байгааг харуулж байгаа юм.

**Хоёр: Асуудлыг үүсгэгч буюу авилгыг үүсгэгч хүчин зүйлс**

Монгол Улсад авилгыг хөгжөөгч нэлээдгүй олон хүчин зүйлс байна. Тухайлбал:

- Нийгмийн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомж нь хэтэрхий ерөнхий, амьдралаас хэт хол тасархай буюу амьдралд нийцэхгүй хууль гарч байгаа нь. Энэ байдал нь хууль батлахад иргэд саналаа төдий л уламжилдаггүй мөн иргэдийн санал нь хуулинд тусахгүй байгаагаас энэ байдал үүсч байгаа юм.
- Төрийн ажилд олон нийтийн хяналт, оролцоо байхгүй мөн төрийн бодлого үйл ажиллагааны талаархи мэдээлэл нийтэд хангалттай очихгүй

<sup>6</sup> www.news.mn

байгаа нь. Мөн төрийн аливаа үйлчилгээ нь хэтэрхий олон шат дамжлага дамждаг байдал.

- Төрийн албан хаагчдын цалин хувийн хэвшилд ажиллаж байгаа хүмүүсээс харьцангуй бага байгаа нь тэднийг албан тушаалаа мөнгө олох хэрэгсэл болгон ашиглахад хүргэж байгаа юм.
- Монголчуудын элгэмсэг зан чанар буюу хамаатаг садан, танил тал, найз нөхдөө гэдэг сэтгэлгээ зэрэг нь авилгыг өгөх, авах буюу үүсгэгч хүчин зүйлс нь болж байгаа юм.

### **Гурав: Асуудлаас гарах гарц буюу иргэдийг эрх зүйн ухамсартай болгох**

Авилгыг шийдвэрлэх хамгийн энгийн шийдэл нь иргэдийг эрх зүйн ухамсартай болгох юм. Одоо тэгвэл хүний ухамсар болоод эрх зүйн ухамсарын тухай товч авч үзэе: Хүний ухамсар гэдэг нь бодит үнэн байдлыг тусгах, хүнд байдаг онцгой шинж мөн.<sup>7</sup> Харин эрх зүйн ухамсар нь нийгмийн ухамсарын нэг хэлбэр бөгөөд эрх зүйн тухай мэдлэг, эрх зүйн тухай үзэл бодол, дүгнэлт, түүний хэрэгжилт, үр нөлөөний хэлбэрээр илэрхийлэгдэж байгаа эрх зүйн бодит байдлын тухай цогцолбор ойлголт юм.<sup>8</sup> Өөрөөр хэлбэл юуг хууль ёсны, юуг хууль бус гэж үзэх тухай хүмүүсийн төсөөлөл, тухайн нийгмийн байгуулал, засаг төрийн эрхийг тэд хэрхэн үзэж байгаа зэрэг нь хүмүүсийн эрх зүйн ухамсарыг бүрдүүлдэг.<sup>9</sup>

Хүн бүр хэрэгжиж байгаа хууль тогтоомж болон нийгэмд хэрэгтэй байгаа хууль тогтоомжийн талаар өөрийн гэсэн тодорхой үзэл бодолтой байдаг байна. Ер нь эрх зүйн ухамсар нь танин мэдэхүйн, мэдээлэх тааварлах, үнлэмжийн болон зохицуулах чиг үүрэг гүйцэтгэдэг байна. Тодруулбал: танин мэдэхүйн чиг үүрэг нь хүний сэтгэн бодох үйл ажиллагааны үр дүнд хууль зүйн тодорхой мэдлэгийг хуримтлуулах явдал юм. Харин үнэлэмжийн чиг үүрэг нь эрх зүйн амьдрал, туршлагын үндсэн дээр эрх зүйн үнэт зүйлст хувь хүний зүгээс хандах сэтгэл зүйн харилцаа юм.

Өдөр тутам хүмүүс нийгмийн амьдралд оролцоходоо бие биедээ нөлөөлж, мэдээлэл дамжуулж, бусдад ямар нэгэн нөлөөлөл үзүүлэхээр эрмэлзэж байдаг

<sup>7</sup> Б.Самбуу “Нийгэм судлалын үндсэн ойлголтын товч толь” ..., УБ хот 1983он. 117-р тал.

<sup>8</sup> Ч.Нямсүрэн “Эрх зүйн ерөнхий онол” ..., УБ хот 2010 он. 124-р тал.

<sup>9</sup> Г.Ганболд “Социалист төр, эрх зүйн зарим асуудлууд” ..., УБ хот. 1987 он. 36-р тал.

байна. Иймд эрх зүйн ухамсартай хүн нь бусдадаа зөв үлгэр дууриалал, нөлөөлөл үзүүлдэг байна. Эрх зүйн зөв ухамсар төлөвшсөн хүн нь эрх зүйн зохицуулалтын хүрээнд ухамсартай, идэвхтэй бүтээлч үйл ажиллагааг байнга явуулдаг. Мөн хуулийг хамгийн үнэ цэнэтэй зүйл гэсэн итгэл үнэмшилд буюу эрх зүйн идеализмд<sup>10</sup> тулгуурлан өөрийн зан үйлийг түүнд тохируулах байдлаар хэрэгжүүлдэг болдог байна. Энэ бүхнээс товч дүгнэхэд эрх зүйн ухамсар нь нийгмийн хөгжил дэвшилд нөлөөлөх гол хүчин зүйл төдийгүй авилгыг устгах хамгийн шидэг арга мөн.

---

<sup>10</sup> Эрх зүйн хэлбэрүүдийн бодит зохицуулах боломжийг үнэлэх хандлага буюу эрх зүйг дэмжих үзэл юм.

## Дүгнэлт

Авилгыг өгөх авахыг хориглосон хууль тогтоомжууд байсаар байхад эх оронд минь авилга ургаа хад чулуу мэт огтоос хөдлөхгүй байгаагийн учир шалтгаан юу вэ? Ерөөс бидний ухамсараас л шалтгаалж байгаа юм. Бидний Монголчууд авилгыг байх ёстой хэвийн үзэгдэл мэт ухамсарлан ойлгох болсонд л хамаг зүйлийн учир байгаа юм. Мөн хуулийн алдаатай зохицуулалтаас болж байгаа юм. Тухайлбал: Эрүүгийн хуулийн 268-р зүйл Хээл хахууль авах, 269-р зүйл Хээл хахууль өгөх, 270-р зүйл Хээл хахууль зуучлах гэж хуульчлан эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан байгаа юм. Хуулийн энэ зохицуулалт нь өгсөн, авсан, зуучилсан гурвууланд нь хариуцлага хүлээлгэхээр мэдээж яаж энэ авилгын гэмт хэргүүд илрэх билээдээ. Ядаж л эрүүгийн хуулийн өгөх гэдгийг хүчингүй болгож авах, зуучлах тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэж авилга, хээл хахууль өгсөн этгээд өөрөө энэ тухайгаа болон үүнийг мэдсэн хүн эрх бүхий байгууллагад мэддэгдвэл зохих урамшуулалд өгдөг болгох. Ийм урамшууллын тогтолцоог бий болговол энэ төрлийн гэмт хэргийн илрүүлэлт ихсэх төдийгүй энэ төрлийн гэмт хэрэг үйлдэгсэд багасах болно.

Илтгэгч миний бодлоор иргэдэд эрх зүйн ухамсарыг төлөвшүүлэх дараахь арга зам байна гэж үзэж байна. Үүнд:

- Хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр Авилгын эсрэг хуулийн тухай мэдээ мэдээллийг иргэдэд ойлгомжтой байдлаар хүргэх, тогтмол сурталчлах.
- Дунд сургуулийн ахлах ангийн сурагчдын хичээлийн хөтөлбөрт нь Авилгын мөн чанар, түүний нийгэмд үзүүлэх хор уршигын тухай хичээлийг оруулах. Учир нь ахлах ангийн сурагчид гэдэг бол дөнгөж нийгмийн амьдралд оролцохоор бэлтгэгдэж байдаг учраас тэднийг эрх зүйн зөв ухамсартай болгох нь нэн чухал юм.

Авилгыг хэн нэгэнд өгөхгүй байх, авахгүй байх мөн авилга өгч, авч байгаа тухай үнэн зөв мэдээлэл байгаа бол түүнийг эрх бүхий байгууллагад мэдээллэх нь Монгол Улсын иргэний Үндсэн хуулинд заасан “Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх”<sup>11</sup> гэсэн үндсэн үүргээ хэрэгжүүлж буй эрхэм зүйл гэдгээ иргэд эрх зүйн ухамсартай болсоноор

<sup>11</sup> “Монгол Улсын Үндсэн хууль”-ийн 19-р зүйлийн 2 дох хэсэг ..., УБ хот. 1992 он.



ухамсарладаг болно. Ер нь *үндсэн үүрэг* гэж иргэдээс төр, нийгэм, бусад иргэдийн өмнө болон улсын аюулгүй байдал, эдийн засгийн хүчин чадлыг бэхжүүлэхийн тулд хууль ёсоор хүлээх үүргийг хэлдэг.<sup>12</sup> Эрх зүйн ухамсартай иргэн л энэ үүргээ хэлбэрэлтгүй биелүүлэх нь тодорхой юм. Өөрөөр хэлбэл улс үндэстний шударга ёсны тогтолцооны амин чухал дэмжлэг бол өөрийн эрхийг мэдэж ухамсарласан, мэдээлэлтэй иргэд юм. Иргэдийн эрх зүйн ухамсартай байхын ач холбогдол нь чухам үүнд л оршиж байгаа юм.

---

<sup>12</sup> Хамтын бүтээл “Монгол Улсын Үндсэн хуулийн нэр томъёоны дагалга” ..., УБ хот. 1993 он.

## Ашигласан материал

**Нэг:** Ном, сурах бичиг

- 1.1. Б.Самбуу “Нийгэм судлалын үндсэн ойлголтын товч толь” .., УБ хот 1983он.
- 1.2. Г.Ганболд “Социалист төр, эрх зүйн зарим асуудлууд” .., УБ хот. 1987 он.
- 1.3. Хамтын бүтээл “Монгол Улсын Үндсэн хуулийн нэр томъёоны дагалга” .., УБ хот. 1993 он.
- 1.4. “Авилга: Мөнхийн үзэгдэл биш” .., УБ хот. 2002 он.
- 1.5. Жереми Поул “Авилгалын эсрэг сурвалж бичиг” .., УБ хот. 2003 он.
- 1.6. Сьюзан Роуз Аккерман “Авилга, төр хоёр” .., УБ хот. 2007 он.
- 1.7. “Авилгыг хэмжихүй” /хэрэглэгчийн гарын авлага/ .., УБ хот. 2010 он.
- 1.8. Ч.Нямсүрэн “Эрх зүйн ерөнхий онол” .., УБ хот 2010 он.

**Хоёр:** Монгол Улсын хууль тогтоомж

- 2.1. Монгол Улсын Үндсэн хууль .., УБ хот. 1992 он.
- 2.2. Эрүүгийн хууль .., УБ хот. 2002 он.
- 2.3. Авилгын эсрэг хууль .., УБ хот. 2006 он.

**Гурав:** Бусад

- 3.1. [www.news.mn](http://www.news.mn)